

ТАНИЛЦУУЛГА

*Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай
хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар*

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогод эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн байх, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэх эрхэм зорилгыг дэвшүүлэн “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, дундаж давхаргыг бүрдүүлнэ”, “Нийгмийн бүх салбарт тэгш бус байдлыг багасгаж, дундаж орлоготой иргэдийн тоог нэмэгдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ”, “Хөрөнгө оруулалтыг бүрэн дэмжсэн, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ”, “Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлснээр урт хугацаанд эдийн засгийн өсөлт дунджаар 6 хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого 2 дахин нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувьд хүргэхээр заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.1-д Татвар, нийгмийн даатгалын шинэчлэлийг хийхээр тусгасан. Үүнд бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой, хүртээмжтэй болгож татварын орчныг сайжруулах, бүсийн ялгаатай татварын тогтолцоог бүрдүүлэх, татвар өр хураах ажиллагааг уян хатан зохицуулдаг болж, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг олон зорилтууд туссан.

Монгол Улс анх 1998 оноос нэмэгдсэн өртгийн албан татварыг нэвтрүүлж, улмаар 2007, 2015 онд уг хуулийг шинэчлэн найруулснаас хойш 10 жил өнгөрсөн байна. Үүнээс хойш цар тахал, геополитикийн нөхцөл байдлаас үүдэн инфляц, төгрөгийн ханш, хүүгийн түвшин нэмэгдэж, энэ үед голчлон бага, дунд орлоготой хувь хүн, өрхийн орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг дэмжих тухай асуудал чухал ач холбогдолтой байна. Иймд иргэдийн эцсийн хэрэглээндээ төлдөг нэмэгдсэн өртгийн албан татварын ачааллыг бууруулж, аж ахуйн нэгжүүдэд үүсгэж буй хүндрэлийг нэг мөр шийдвэрлэх шаардлагын дагуу хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.

Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар хамтран улс орон даяар давхардсан тоогоор 11,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 150 мянга орчим санал хүлээн авсан. Хэлэлцүүлгийн үр дүнд суутган төлөгчийн босго нэмэгдүүлэх, үндсэн хөрөнгийн худалдан авалтад төлсөн татварыг шууд хасах, ажил эрхлэлтийг дэмжсэн

хөшүүргийг бий болгох, орлого хүлээн зөвшөөрөх суурь зарчмыг өөрчлөх, бүх нийтээрээ жигд төлдөг байх зэрэг саналуудыг нийтлэг байдлаар ирүүлсэн байна.

Энэхүү нөхцөл байдлыг харгалзан татварын бодлогыг илүү уян хатан, ойлгомжтой болгох, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өрхийн татварын ачааллыг бууруулах, хөнгөлөлт чөлөөлөлтийг илүү оновчтой, хүртээмжтэй болгох чиглэлээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг шинэчлэн найруулах шаардлага үүссэн байна.

Дээрх үндэслэл, шаардлагын дагуу Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дараах үндсэн зорилгод нийцүүлж боловсрууллаа. Үүнд:

- 1. Иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалах**
Нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг олон улсын чиг хандлага, зарчимд нийцүүлэн оновчтой, хүртээмжтэй болгох замаар иргэдийн төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг шаталсан хэлбэрээр 100 хүртэл хувиар буцаан олгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгав.
- 2. Бизнесийн идэвхжилийг дэмжих, аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаагаа тэлэх боломжийг олгох**
Аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгийн хомсдол, эргэлтийн хөрөнгийн дарамтыг бууруулж, бүх нийтээрээ тэгш шударга төлж, бизнес эрхлэхэд нэмэлт дарамт болдоггүй байх нөхцөлийг бүрдүүлсэн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгав.

Түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтын хүрээнд ажилчдын хөгжил, хүний нөөцийн бодлогыг дэмжих, ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад татварын тодорхой дэмжлэгийн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэн, өрхийн хэрэглээндээ төлдөг татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалж, бизнес, ажил эрхлэлтийг дэмжих ба нэмэгдсэн өртгийн албан татварыг олон улсын жишгийн дагуу хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Гадаадын хөрөнгө оруулагчдын татварын орчныг илүү таатай болгож хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, татварын орчныг өрсөлдөхүйц болгоно. Аж ахуйн нэгжүүд гадаадын хөрөнгө оруулалтыг илүү хялбар, зардал багатайгаар татах боломжтой болсноор улс орны нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэх, эдийн засгийн идэвхжил өсөхөд хувь нэмэр оруулах юм.

Татварын хуулийн шинэчлэл нь бизнес эрхлэгчдэд тулгарч буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэж, аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн дарамтыг бууруулж, бизнесийн идэвхжих, тэлэх бололцоог ханган, үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

Цаашид хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан системийг нэвтрүүлснээр татвар төлөгчид шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй авч, татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхтэй холбоотой асуудлуудыг урьдчилан

шийдвэрлэж, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд, хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаа, нийгэм, эдийн засагт эергээр нөлөө үзүүлнэ.

---oOo---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогод эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн байх, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэх эрхэм зорилгыг дэвшүүлэн “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, дундаж давхаргыг бүрдүүлнэ”, “Нийгмийн бүх салбарт тэгш бус байдлыг багасгаж, дундаж орлоготой иргэдийн тоог нэмэгдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ”, “Хөрөнгө оруулалтыг бүрэн дэмжсэн, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ”, “Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлснээр урт хугацаанд эдийн засгийн өсөлт дунджаар 6 хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого 2 дахин нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувьд хүргэхээр заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.1-д Татвар, нийгмийн даатгалын шинэчлэлийг хийхээр тусгасан. Үүнд бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой, хүртээмжтэй болгож татварын орчныг сайжруулах, бүсийн ялгаатай татварын тогтолцоог бүрдүүлэх, татвар өр хураах ажиллагааг уян хатан зохицуулдаг болж, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг олон зорилтууд туссан.

Монгол Улс анх 1998 оноос нэмэгдсэн өртгийн албан татварыг нэвтрүүлж, улмаар 2007, 2015 онд уг хуулийг шинэчлэн найруулснаас хойш 10 жил өнгөрсөн байна. Үүнээс хойш цар тахал, геополитикийн нөхцөл байдлаас үүдэн инфляц, төгрөгийн ханш, хүүгийн түвшин нэмэгдэж, энэ үед голчлон бага, дунд орлоготой хувь хүн, өрхийн орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг дэмжих тухай асуудал чухал ач холбогдолтой байна. Иймд иргэдийн эцсийн хэрэглээндээ төлдөг нэмэгдсэн өртгийн албан татварын ачааллыг бууруулж, аж ахуйн нэгжүүдэд үүсгэж буй хүндрэлийг нэг мөр шийдвэрлэх шаардлагын дагуу хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.

Монгол Улсын хувьд жижиг, дунд бизнес эрхлэгчдийн төлбөрийн чадвар буурах, мөнгөн хөрөнгийн хомсдолд орох, улмаар бизнесийн тогтвортой байдлаа хадгалах болон хөрөнгө оруулалт шинээр татахад хүндрэл үүсэж байна. Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар аж ахуйн нэгжүүдийн 57 орчим хувь нь мөнгөн хөрөнгийн дутагдалтай байгаа нь 2019 оныхтой харьцуулахад 27 хувиар өссөн үзүүлэлт юм. Мөн нийт аж ахуйн нэгжүүдийн 34 хувь буюу 32 мянга гаруй компани

алдагдалтай ажилласан байна. Түүнчлэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2019 оноос ердөө 13 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Иймээс дээрх нөхцөл байдлыг шийдвэрлэхийн тулд татварын бодлогын холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага бий болж байна.

Түүнчлэн, өнгөрсөн 2023 оны байдлаар иргэдийн төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын 20 хувийн буцаан олголтын урамшууллаар нийт 316 тэрбум төгрөгийг 1.7 сая иргэнд олгосон байна. Үүнээс хэрэглээ өндөртэй, чинээлэг хэсэг буюу нийт иргэдийн 13 хувь нь нийт буцаан олголтын 60 хувийг авсан байгаа нь өнөөгийн хэрэгжиж буй нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг оновчтой, хүртээмжтэй болгон сайжруулах шаардлага үүсэж байна.

Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар хамтран улс орон даяар давхардсан тоогоор 11,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 150 мянга орчим санал хүлээн авсан. Хэлэлцүүлгийн үр дүнд суутган төлөгчийн босго нэмэгдүүлэх, үндсэн хөрөнгийн худалдан авалтад төлсөн татварыг шууд хасах, ажил эрхлэлтийг дэмжсэн хөшүүргийг бий болгох, орлого хүлээн зөвшөөрөх суурь зарчмыг өөрчлөх, бүх нийтээрээ жигд төлдөг байх зэрэг саналуудыг нийтлэг байдлаар ирүүлсэн байна.

Энэхүү нөхцөл байдлыг харгалзан татварын бодлогыг илүү уян хатан, ойлгомжтой болгох, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өрхийн татварын ачааллыг бууруулах, хөнгөлөлт чөлөөлөлтийг илүү оновчтой, хүртээмжтэй болгох чиглэлээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг шинэчлэн найруулах практик шаардлага үүссэн байна.

Дээрх үндэслэл, шаардлагын дагуу Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дараах үндсэн зорилгод нийцүүлж боловсрууллаа. Үүнд:

- 1. Иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалах**
Нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг олон улсын чиг хандлага, зарчимд нийцүүлэн оновчтой, хүртээмжтэй болгох замаар иргэдийн төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг шаталсан хэлбэрээр 100 хүртэл хувиар буцаан олгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгав.
- 2. Бизнесийн идэвхжилийг дэмжих, аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаагаа тэлэх боломжийг олгох**
Аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгийн хомсдол, эргэлтийн хөрөнгийн дарамтыг бууруулж, бүх нийтээрээ тэгш шударга төлж, бизнес эрхлэхэд нэмэлт дарамт болдоггүй байх нөхцөлийг бүрдүүлсэн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгав.

Түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтын хүрээнд ажилчдын хөгжил, хүний нөөцийн бодлогыг дэмжих, ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад татварын тодорхой дэмжлэгийн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

Хуулийн төслийн бүтэц нь 7 бүлэг, 24 зүйлээс бүрдэх бөгөөд дараах агуулгатай байна. Үүнд:

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт. Хуулийн зорилт, хамрах хүрээ, нэр томьёоны тодорхойлолт зэрэг нийтлэг харилцааны талаар тусгалаа. Хуулийн төслийн хүрээнд нэмэгдсэн өртгийн албан татварыг ногдуулах, түүнийг тайлагнах, төлөх, буцаан олгохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа нь одоо хүчинтэй хуулийн зорилготой ижил байна.

Энэ хуультай холбоотойгоор шинэ нэр томьёог бий болгоогүй. Гэхдээ одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хүрээнд хэрэглэж байгаа бараа, борлуулалт зэрэг нэр томьёог олон улсад хэрэглэгдэж байгаа агуулгаар томьёолсон. Тодруулбал,

- Бараа гэдэгт нь мөнгөн хөрөнгөөс бусад бүх хөрөнгийг хамруулж байгаа нь биет бус хөрөнгийг ч бараатай ижилтгэх нөхцөл үүсэж байгааг өөрчилж, барааг эд хөрөнгө байхаар тодорхойлов.
- Борлуулалт гэдэг нь одоогийн хуулиар бараа, ажил, үйлчилгээг шилжүүлэх гэсэн ерөнхий агуулгатай байсныг тодруулж, мөнгө, болон түүнтэй адилтгах үнэ цэнээр үнэлж барааг бусдын эзэмшил, ашиглалт, өмчлөлд шилжүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхийг гэж тодруулсан.
- Мөн хуулийн зүйл, заалтуудыг нягтлан бодох бүртгэлийн үг агуулгатай ижилтгэж, нэмэгдсэн өртгийн албан татварын авлага, өглөг, эцсийн тооцоо хийх зэрэг ойлголтуудыг тодорхойлсон.

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт татвар төлөгч, түүнд үзүүлэх хөнгөлөлтийн талаар тусгасан. Өөрөөр хэлбэл, нэмэгдсэн өртгийн албан татварыг эцсийн хэрэглэгч иргэн төлдөг тул энэ агуулгаар эцсийн хэрэглээний худалдан авалтаа татварын албанд бүртгүүлсэн татвар төлөгчид татварын хөнгөлөлт үзүүлэх асуудлыг хуулийн төсөлд тусгасан. Энэхүү хөнгөлөлтийг хувь хүний сарын худалдан авалтаас хамаарч харилцан ялгаатай үзүүлэхээр тогтоосон. Тодруулбал, 500,000 төгрөг хүртэлх худалдан авалтад төлсөн татварыг 100 хувь, 500,001-800,000 төгрөг хүртэлх худалдан авалтад төлсөн татварыг 50 хувь, 800,001 төгрөгөөс дээш худалдан авалтад төлсөн татварыг 20 хувиар хөнгөлж, буцаан олгоно.

Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт татвар суутган төлөгч, түүнийг бүртгэх, бүртгэлээс хасах харилцааг тусгасан. Тухайлбал, иргэн, хуулийн этгээдийн дараалсан 12 сарын борлуулалтын орлогын хэмжээ нь 400 сая төгрөгт хүрсэн бол уг этгээд нь татвар суутган төлөгчөөр бүртгэгдэх асуудлыг тусгасан. Татвар суутган төлөгчийн бүртгэлийг төлбөрийн баримтад үндэслэн татварын албаны бүртгэл мэдээллийн сангаас шууд бүртгэх зохицуулалтыг бий болгосон. Түүнчлэн, зөвхөн хөдөлмөрийн гэрээ бус хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын шимтгэл ногдох борлуулалтын орлого олсон хөдөлмөр эрхлэгчийг татвар суутган төлөгчөөр бүртгэхгүй байх зохицуулалтыг бий болгосон. Энэ босгын хэмжээг нэмэгдүүлснээр жижиг бизнес эрхлэгчдэд бий болдог татварын удирдлагын зардлыг хэмнэх нөхцөл үүсэж байна.

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт татвар ногдох зүйл, ногдуулах харилцаа, борлуулалт хүлээн зөвшөөрөх, үнэлгээ тооцох, хувь хэмжээ тогтоох болон албан татвараас чөлөөлөх харилцааг тус тус зохицуулна. Татвар ногдох зүйлийн хувьд биет бус хөрөнгөд татвар ногдуулах асуудлыг үйлчилгээний төрөлд хамруулсан. Хуулийн төслөөр татварын хувь хэмжээг өөрчлөөгүй бөгөөд бараа ажил, үйлчилгээний дотоодын борлуулалт, импортод 10 хувиар татвар ногдуулах бол экспортод 0 хувийн татвар ногдуулахаар заасан. Татварын чөлөөлөлтийн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж байна. Тодруулбал, татвараас чөлөөлөх санхүүгийн үйлчилгээний хүрээг хуулийн төсөлд тодорхойлсон.

Хуулийн төсөлд орсон зарчмын томоохон өөрчлөлт нь борлуулалт хүлээн зөвшөөрөх харилцаа нь мөнгөн болон аккрузал суурь хосолмол байсныг өөрчилж, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого хүлээн зөвшөөрөх зарчимтай ижил болгосон.

Хуулийн төслийн тавдугаар бүлэгт татвар төлөгчийн худалдан авалтад ногдуулах албан татварын харилцаа буюу татварын авлага, түүний бүртгэл, албан татвараас хасах эцсийн тооцоо хийх харилцааг тусгасан. Энэхүү бүлэгт тусгасан шинэ харилцаа нь худалдан авагч талаас төлбөрийн баримтыг үйлдэх боломжийг бүрдүүлсэн. Өөрөөр хэлбэл хэлцлийн, татварын албанд хүлээн зөвшөөрөгдөх борлуулалт, худалдан авалтыг зөвхөн нэг тал болох борлуулагч үйлддэг байсныг өөрчилж, аль ч талаас буюу худалдан авагч тал нь төлбөрийн баримт үйлдэх боломжтой болсон. Ингэснээр татвар ногдох борлуулалтыг бүртгэх боломжийг илүү хялбаршуулсан. Улмаар энэхүү худалдан авалтын төлбөрийн баримтыг үндэслэн татвар суутган төлөгч нь худалдан авалтын хасалтаа хийх, татвараа төлснөөс буцаан авалт хийх эрх нь үүснэ.

Түүнчлэн, оршин суугч бус этгээдийн Монгол Улсад үзүүлсэн үйлчилгээнд ногдсон татварыг хасдаггүй байсныг өөрчилж, татвар суутган төлөгч нь уг үйлчилгээнд төлсөн татварыг буцаан авах боломжтой болсон.

Мөн хуульд заасан зарим хязгаарлалтуудыг өөрчилж, бизнес эрхлэгч нарт илүү ээлтэй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хуулийн төсөлд тусгасан. Тодруулбал, ажилчдын хэрэгцээнд зориулж худалдаж авсан бараа, үйлчилгээний худалдан авалт, мөн ажилчдыг сургах, мэргэжил дээшлүүлэхтэй холбоотой төлсөн төлбөрт ногдох татварыг хасахгүй байсныг өөрчилж, тодорхой хязгаартайгаар хасах боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн, үндсэн хөрөнгийн худалдан авалтад төлсөн татварыг үе шаттай хасагдуулж байсныг өөрчилж шууд хасагдуулахаар өөрчилсөн.

Хуулийн төслийн зугадугаар бүлэгт татвар тайлагнах, төлөх, илүү төлсөн татварыг буцаан олгох харилцааг зохицуулах мөн энэ бүлэгт төлөх татварыг хойшлуулах харилцааг тусгасан. Энэ бүлэгт татвар төлөгчдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн дарамтыг бууруулах зорилгоор татвар төлөх хугацааг илүү уян, хатан болгосон. Тухайлбал, хугацааг хууль мөрдөлтийн түвшинтэй уялдуулан татвар төлөгчийн татвар төлөх хугацааг 6 сар хүртэл хугацаагаар сунгах шинэ зохицуулалтыг тусгасан. Түүнчлэн одоогийн хэрэгжиж буй хууль, тогтоомжоор татвар төлөгч тухайн сарын борлуулалттай холбоотой нэмэгдсэн өртгийн албан

татварын тайланг дараа сарын 10-ны өдөр тайлагнаж төлөхөөр зохицуулалттай байгааг нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг илгээсэн өдрөөс 5 хоногийн дараа төлөх үүрэг үүсэхээр хуулийн төсөлд зохицуулсан.

Хуулийн төслийн долдугаар бүлэгт хуулийг шинэчлэн баталсантай холбоотой шилжилтийн үеийн зохицуулалтыг болон хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгасан. Хууль нь 2026 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжинэ.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэн, өрхийн хэрэглээндээ төлдөг татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалж, бизнес, ажил эрхлэлтийг дэмжих ба нэмэгдсэн өртгийн албан татварыг олон улсын жишгийн дагуу хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Гадаадын хөрөнгө оруулагчдын татварын орчныг илүү таатай болгож хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, татварын орчныг өрсөлдөхүйц болгоно. Аж ахуйн нэгжүүд гадаадын хөрөнгө оруулалтыг илүү хялбар, зардал багатайгаар татах боломжтой болсноор улс орны нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэх, эдийн засгийн идэвхжил өсөхөд хувь нэмэр оруулах юм.

Татварын хуулийн шинэчлэл нь бизнес эрхлэгчдэд тулгарч буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэж, аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн дарамтыг бууруулж, бизнесийн идэвхжих, тэлэх бололцоог ханган, үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

Цаашид хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан системийг нэвтрүүлснээр татвар төлөгчид шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй авч, татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхтэй холбоотой асуудлуудыг урьдчилан шийдвэрлэж, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд, хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаа, нийгэм, эдийн засагт эергээр нөлөө үзүүлнэ.

Хуулийн төслийн нийцлийг хангах хүрээнд тус хуулийг ишилсэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Банкны тухай хууль, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Нотариатын тухай хууль, Хотын албан татварын тухай хуульд тус тус шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулсан. Түүнчлэн, хуулийн шинэчлэн найруулж байгаатай холбоотойгоор 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хүчингүй болгох хуулийн төслийг боловсруулсан болно.

---oOo---

INTRODUCTION

Revised Draft of the Law on Value-Added Tax

The long-term policy document "Vision 2050," approved by Resolution No. 52 of the State Great Khural of Mongolia, aims to establish an economy that is equitable and accessible to every household and citizen by enhancing the competitiveness of small and medium-sized enterprises (SMEs), fostering a favorable investment environment, and creating conditions conducive to the growth of competitive micro, small, and medium-sized businesses. The policy outlines key objectives, including supporting employment and ensuring steady household income growth to strengthen the middle class, reducing inequalities across all sectors while increasing the number of middle-income citizens and improving quality of life. It also aims to create a fully supportive investment environment to foster a favorable business climate and develop internationally competitive micro, small, and medium-sized enterprises to generate more employment opportunities.

The mid-term development program "New Recovery Policy," approved by Resolution No. 106 of the State Great Khural of Mongolia on December 30, 2021, aims to sustain an average economic growth rate of 6% over the long term, double the national income per capita, and increase the labor force participation rate to 65%.

Mongolian Government Action Plan for 2024-2028, approved by State Great Khural Resolution No. 21 in 2024, a commitment to tax and social insurance reforms under section 3.2.1. These reforms aim to reduce the tax burden on low- and middle-income citizens, optimize the effectiveness and accessibility of tax incentives to improve the tax environment, create a regionally differentiated tax system, and support compliant taxpayers.

Mongolia first introduced the Value-Added Tax (VAT) in 1998 and subsequently revised the law in 2007 and 2015. A decade has passed since the last amendment, during which economic challenges such as the COVID-19 pandemic, geopolitical uncertainties, inflation, currency depreciation, and rising interest rates have significantly impacted the economy. These challenges have particularly impacted low- and middle-income individuals and households, highlighting the need for measures to protect their income, support employment, and improve the liquidity and current asset of businesses. In response, a revised draft of the VAT law has been developed to reduce the tax burden on taxpayer and address the financial difficulties faced by enterprises.

In Mongolia, small and medium-sized enterprises (SMEs) are facing increasing difficulties in maintaining financial stability due to declining payment capacity, liquidity shortages, and challenges in sustaining business operations and attracting new investments. As of 2023, approximately 57% of enterprises across the country experienced cash flow shortages, marking a 27% increase compared to 2019. Additionally, 34% of all enterprises, or more than 32,000 companies, operated at a loss. Furthermore, foreign direct investment has grown by only 13% since 2019. Given these circumstances, the implementation of relevant tax policy measures has become necessary to address these financial and investment challenges.

In 2023, a total of 316 billion MNT was refunded to 1.7 million citizens as part of the 20% Value-Added Tax (VAT) refund. However, 13% of the population, primarily high-consumption and affluent individuals, received 60% of the total refunds. This disparity highlights the need to refine and improve the current VAT exemption and refund policies to ensure they are more targeted, equitable, and accessible to a broader segment of the population.

The Ministry of Finance, tax and customs authorities, the Mongolian National Chamber of Commerce and Industry, and the Secretariat of the State Great Khural jointly organized 150 meetings and discussions nationwide, engaging over 11,000 taxpayers and collecting approximately 150,000 suggestions. As a result of these consultations, several key recommendations were commonly raised, including increasing the VAT threshold for registered taxpayers, allowing immediate deduction of VAT paid on fixed asset purchases, introducing incentives to promote employment, modifying the fundamental principles of revenue recognition, and ensuring a more uniform tax burden across all taxpayers.

Given these circumstances, there is a practical necessity to revise the Value-Added Tax Law to make tax policies more flexible and transparent, support business operations, attract investment, reduce the tax burden on households, and ensure that tax exemptions and relief measures are more targeted and accessible.

Based on the aforementioned justifications and requirements, the revised draft of the Value-Added Tax Law has been developed in alignment with the following key objectives:

1.Reducing the tax burden on individuals and households while protecting real income – The draft law introduces a structured mechanism for refunding up to 100% of the Value-Added Tax (VAT) paid by citizens, ensuring that VAT exemptions and relief measures are more targeted and accessible in accordance with international trends and principles.

2.Supporting business activity and enabling enterprises to expand – The draft law includes provisions to alleviate liquidity shortages and constraints on current asset , ensuring that VAT obligations are equitably distributed among all taxpayers without imposing additional financial burdens on businesses.

Additionally, in line with the objective of promoting employment, the draft law incorporates specific tax incentives to support workforce development, enhance human resource policies, and improve workplace conditions.

The structure of the draft Value-Added Tax Law consists of 7 chapters and 24 articles, covering the following key aspects:

The first chapter of the draft law outlines the objectives, scope, and definitions of key terms, covering general provisions related to VAT regulations. It establishes the legal framework for the imposition, reporting, payment, and refund of Value-Added Tax (VAT), ensuring continuity with the objectives of the current law while refining and clarifying its provisions.

The draft law does not introduce new terminology but refines existing terms in alignment with international practices. Specifically:

Goods: Previously, the term encompassed all assets except cash, which led to the classification of intangible assets as goods. The revised definition now explicitly defines goods as tangible property, distinguishing them from intangible assets.

Sales: Under the current law, sales were broadly defined as the transfer of goods, work, or services. The revised definition clarifies that sales involve the transfer of goods into the ownership, possession, or use of another party, or the provision of work and services, with valuation based on money or equivalent value.

Accounting Consistency: The provisions of the law have been aligned with accounting terminology, ensuring clarity on VAT-related receivables, payables, and final settlements.

These refinements enhance legal clarity, ensuring consistency with international tax principles and accounting standards.

The second chapter of the draft law defines taxpayers and establishes a progressive VAT refund system to provide tax relief to registered taxpayers based on their final consumption purchases. Since VAT is ultimately borne by the taxpayer, the law introduces a tiered refund mechanism to ensure fairness and accessibility. Under this system, VAT paid on purchases up to 500,000 MNT is credited (100%), purchases between 500,001–800,000 MNT qualify for a 50% credit, and purchases exceeding 800,001 MNT receive a 20% credit. This approach aims to alleviate the tax burden, particularly for lower- and middle-income consumers, while maintaining an equitable and efficient tax system.

The third chapter of the draft law regulates the registration and deregistration of VAT-withholding taxpayers. It stipulates that individuals or legal entities must register as VAT payers if their cumulative sales revenue over 12 consecutive months reaches 400 million MNT. The law introduces an automated registration system, where businesses are directly registered in the tax administration's database based on payment receipts. Additionally, it specifies that individuals earning taxable revenue subject to social insurance contributions under labor laws—excluding those solely under employment contracts—will not be required to register as VAT payers. By increasing the registration threshold, the law aims to reduce tax compliance costs for small businesses, allowing them to operate with greater financial flexibility.

The fourth chapter of the draft law regulates taxable items, tax assessment, revenue recognition, valuation, tax rates, and exemptions. It includes intangible assets within the taxable scope by categorizing them as a type of service. The draft does not change the existing tax rates, maintaining a 10% VAT on domestic sales and imports while applying a 0% VAT rate on exports. Additionally, tax exemption provisions have been revised to align with international standards, particularly by clearly defining the scope of financial services eligible for VAT exemption.

The fifth chapter of the draft law governs VAT-related obligations on purchases, including tax receivables, record-keeping, and final tax deductions. A key innovation introduced in this chapter is the ability for buyers to issue payment receipts, rather than limiting this function solely to sellers. Previously, only the seller could issue tax-recognized sales and purchase receipts, but the revised law allows either party—buyer or seller—to generate an official payment receipt. This change simplifies the process of recording taxable sales, ensuring more accurate tax reporting. Consequently, VAT-registered taxpayers can use these purchase receipts as the basis for deducting VAT on eligible expenses and claiming tax refunds.

Additionally, the draft law introduces a significant change by allowing VAT-registered taxpayers to claim refunds on VAT paid for services provided by non-resident entities in Mongolia. Previously, VAT incurred on such services was non-deductible, but under the revised provisions, businesses can now recover the VAT paid on these transactions, ensuring a more equitable and competitive tax environment.

The draft law also introduces business-friendly reforms to support entrepreneurship and employment by modifying certain tax restrictions. Notably, VAT paid on purchases of goods and services for employee needs, as well as expenses related to employee training and professional development, was previously non-deductible. The revised law now allows businesses to deduct these expenses within specified limits. Additionally, the VAT deduction process for fixed asset purchases has been streamlined—rather than deducting it gradually over time, businesses can now claim the full deduction immediately, improving cash flow and reducing financial burdens.

The sixth chapter of the draft law regulates VAT reporting, payment, refunds for overpaid taxes, and tax deferrals. To ease cash flow constraints for taxpayers, the law introduces a more flexible tax payment schedule, allowing taxpayers to defer VAT payments for up to six months, depending on their compliance status. Additionally, under the current law, taxpayers must submit their VAT report by the 10th day of the following month and make the corresponding payment on the same date. The revised law modifies this requirement by stipulating that the VAT payment will be due five days after the submission of the VAT report, providing businesses with additional time to manage their financial obligations.

The seventh chapter of the draft law outlines transitional provisions related to the implementation of the revised legislation and specifies its effective date. The law is set to come into force on January 1, 2026, ensuring a smooth transition period for taxpayers and relevant institutions to adapt to the new regulatory framework.

Once enacted, the revised law will reduce the tax burden on individuals and households, protect real income, and support business growth and employment. Additionally, it will align Mongolia's Value-Added Tax (VAT) system with international best practices, ensuring a more equitable and efficient tax framework that fosters economic stability and development.

The revised law will create a more favorable tax environment for foreign investors, enhancing investment attractiveness and making Mongolia's tax system more competitive. By simplifying procedures and reducing costs associated with attracting

foreign investment, businesses will find it easier to secure international capital. This, in turn, is expected to increase overall investment levels, stimulate economic activity, and contribute to sustained economic growth.

The tax law reform aims to address common challenges faced by businesses, alleviating cash flow and current asset constraints while fostering business expansion and growth opportunities. By reducing financial pressures, the revised law will enable enterprises to operate more efficiently, increase their market activity, and scale their operations, ultimately contributing to a more dynamic and resilient business environment.

Moving forward, the integration of artificial intelligence (AI) and big data-driven systems will enable taxpayers to access real-time information, proactively address compliance issues, and streamline tax administration. This technological advancement will enhance regulatory transparency and efficiency, ultimately facilitating business operations, attracting investment, and positively impacting Mongolia's economic and social development.

To ensure legal consistency, necessary amendments have been made to the Customs Tariff and Customs Tax Law, Banking Law, Law on the Legal Status of Professional Associations, Notary Law, and City Tax Law, all of which reference the revised VAT law. Additionally, due to the comprehensive revision, a separate bill has been drafted to repeal the existing Value-Added Tax Law of July 9, 2015, ensuring a seamless transition to the new legal framework.

---oOo---